# ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТАД ЦАХИМ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

**Т.ТҮМЭННАСАН**

*Нийслэлийн Онцгой байдлын газран Чингэлтэй дүүргийн
Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч,
ахмад, удирдахуйн ухааны магистр

**Хураангуй**

*Гал түймрийн хяналт гэдэг нь онолын хувьд гал түймрийг үүсгэгч гол элементүүд болох дулаан, агаар (хүчилтөрөгч), түлш (шатах материал)-ыг нөхцөлдүүлэхгүй буюу галын гурвалжинг бий болгохгүй байх, үүсвэрлэн гарсан тохиолдолд цаашид хөгжин дэлгэрүүлэхгүй байх тухай ойлголт юм. Гал түймрийн улсын хяналт нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гал түймрийн хяналтын хэлтсийн байцаагч нарын гүйцэтгэдэг төрийн хяналтын үйл ажиллагааны тусгай төрөл юм.*

*Гал түймрийн улсын хяналтын эрх бүхий албан тушаалтан нар болон иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын хамтын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох төрийн үйлчилгээг ойртуулах бүх төрлийн мэдээллийг цахим системд багтаах зайлшгүй шаардлага тулгарч байна. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам"-ыг баталсан. Судалгаанаас үзэхэд Нийслэл хотын хэмжээнд 1 гал түймрийн улсын хяналтын байцаагчид 3076 барилга байгууламж байгаа нь тухайн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн барилга байгууламжид нэг бүрчлэн хүрч ажиллах боломж нөөц, цаг хугацаанаас шалтгаалсан чанар хүртээмж муу байна тиймээс цаашид энэ төрлийн үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлж иргэн хуулийн этгээдтэй хамтран ажиллахад төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломжтой гэж дүгнэж байна.*

**Түлхүүр үг:** гал түймэр, гал түймрийн хяналт, цахим систем.

**Судалгааны ажлын үндэслэл:** Монгол Улсын хурдацтай хөгжлийг дагалдан хүмүүсийн материаллаг аж байдал дээшлэхийн хирээр улсын болон аж ахуй, үйлдвэрийн төрөл бүрийн салбарууд, иргэдийн амь нас, эд хөрөнгийг гал түймрээс хамгаалах ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан зохион байгуулах асуудал хурцаар тавигдсаар байна.

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гал түймрийн улсын хяналтын эрх бүхий албан тушаалтан нар болон иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын хамтын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох төрийн үйлчилгээг ойртуулах бүх төрлийн мэдээллийг цахим системд багтаах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Галын байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Улсын Их хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж шинэчлэн баталсантай холбогдуулан иргэн, аж ахуй нэгж байгууллагын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохицуулах, хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр нийт 20 дүрэм, журам, заавар, стандартууд батлагдан гарсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь галын аюулгүй байдлаа хэрхэн хангасан талаарх дүгнэлтийг мэргэжлийн байгууллага болох Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаар гаргуулан үйл ажиллагаагаа эрхэлдэг бөгөөд энэхүү төрийн үйлчилгээг түргэн шуурхай авахад хүндрэлтэй байдаг байна. Тухайлбал, аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд иргэдээс материал хүлээн авах, барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах норм стандартын техник, тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмжийн бүрдлийн жагсаалт, галын аюулгүй байдлын хяналт шалгалт, зөрчил дутагдлын мэдээлэл, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгогдсон эсэх зэрэг бүх төрлийн мэдээллийг цахим системд багтааж бүртгэлжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь энэхүү сэдвийг сонгон авч судлах үндэслэл болж байна.

**Судлагдсан байдал:** Гал түймэртэй тэмцэх арга замыг сайжруулах, унтраах үйл ажиллагаанд тулгамдсан асуудал, удирдлага зохион байгуулалт зэрэг ерөнхий сэдвийн хүрээнд авч үзсэн бүтээлүүд нилээд хэд байдаг. Харин гал түймрийн улсын хяналтын чиглэлээр хошууч Д.Бат-Эрдэнэ Тал түймрийн улсын хяналтыг сайжруулах арга зам"

сэдвээр удирдахуйн ухааны магистрийн зэрэг горилсон ажил 2020 онд хийсэн бөгөөд энэхүү ажил нь Гал түймрийн улсын хяналтын эрх зүйн зохицуулалт, баримт бичгийн боловсруулалтыг сайжруулах, орон тоо нөхөн хангалтын талаас нь авч үзжээ. Өнөөгийн байдлаар гал түймрийн хяналтад цахим системийг нэвтрүүлэх боломжийг судалсан бүтээл хараахан байхгүй байна.

**Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх арга зүйн үндэс**

Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх арга зүйн үндсийг судлахдаа гал түймрийн хяналт гэж юу болох тухай юуны өмнө авч үзэх нь зүйтэй юм.

Гал түймрийн хяналт гэдэг нь онолын хувьд гал түймрийг үүсгэпч гол элементүүд болох дулаан (шүдэнз, лаа, цахилгаан, химийн урвал), агаар (хүчилтөрөгч), түлш (шатах материал)-ыг нөхцөлдүүлэхгүй буюу галын гурвалжинг бий болгохгүй байх, үүсвэрлэн гарсан тохиолдолд цаашид хөгжин дэлгэрүүлэхгүй байх тухай ойлголт юм.

Гал түймрийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох түлш, дулаан, хүчилтөрөгч гурвын аль нэг нь байхгүй бол гал түймэр үүсвэрлэн гарахгүй, эсвэл үргэлжлэн шатахгүй. Өөрөөр хэлбэл шаталтын процесст оролцож буй элемент бүр (зураг 1), мөн химийн урвалыг нөхцөлдүүлэгчийг багасгах, арилгах, хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг гал түймрийн хяналт гэж ойлгоно.

Гал үүсгэх з нөхцөл бүрдсэнээс гал гарч гал түймрийн 4 дэх хүчин зүйл буюу цаашид дамжин шатах эд зүйл, бодис материал байгаа тохиолдолд ассан гал нь гал түймэр болон өргөжин дэлгэрдэг. Үүнийг галын дөрвөн талт (тетраэдр) гэнэ.

Зураг 1. Гал түймрийн тетраэдр




Гал түймрийн аюулгүй байдлыг хангахын тулд элементүүдэд чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Үүнд:

а. Дулаан- бий болгохгүй багасгах
б. Түлш- зайлуулах, таслах, арилгах
в. Агаар \хүчилтөрөгч\-хязгаарлах, битүүмжлэх
г. Химийн урвал- Гал унтраах бодис /нунтаг, хий/ урвалаар удаашруулах

1985 онд АНУ-ын Финиксийн галын албаны дарга асан Alan Brunacini гал түймрийн эсрэг хариу арга хэмжээ авахдаа гал түймрийн хяналттай холбоотой 2 үндсэн үйл ажиллагааг тодорхойлсон байна . Үүнд:

1. Гал түймрийн тархан дэлгэрэлтийг хязгаарлан гал түймрийг хянах \унтраах\ үйл ажиллагаа,
2. Гал түймрийн талбай дээр нь хяналтад оруулах. Энэ нь гал түймрийг цаашид тархан дэлгэрүүлэхгүйгээр анхны голомтод нь зогсоож байгаа нөөцийг ашиглан унтраах буюу аюулыг бууруулах үйл ажиллагаа юм. Дээрх тодорхойлолт ойлголтуудаас үзэхэд гал түймрийн хяналтын 2 тал байх ба 1-р тал нь гал түймрийг үүсвэрлэн гаргахгүй байхад чиглэсэн хяналт, 2-р тал нь гал түймрийг хөгжин дэлгэрүүлэхгүй байхад чиглэсэн хяналт байна.

Зураг 2. Гал түймэр, түүнээс аврах ажиллагааны хяналтын аргачлал.




Хяналтын 2 талын хоорондын хамаарлыг зураг 2-д үзүүлэв. Энэхүү онол нь гал түймрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны жишиг загвар болж чадна гэж Worm (1998) болон Brehmer (2000) нар үздэг байна. Зургийн баруун гар тал дахь хяналтыг хууль, эрхзүйн баримт бичгийн тусламжтайгаар хэрэгжүүлдэг бол зүүн гар тал хяналтыг хийц бүтээц, тоног төхөөрөмж, гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, автомат тоног төхөөрөмж, хууль эрх зүйн баримт бичгийн тусламжтайгаар хэрэгжүүлдэг.

Америкийн Нэгдсэн Улсад галыг A, B, C, D, K ангиллын гал гэж ангилдаг боловч бусад улс оронд өөр өөр төрлөөр ангилдаг байна (Fire control. 2022). Ангилал бүр нь гал түймрийн тодорхой төрөл бөгөөд түүний шалтгаанаас хамааран хяналтын аргыг шаарддаг. Гал унтраагуурыг зөв ашиглахын тулд шалтгааныг ойлгох нь чухал хэрэв гал унтраагуурыг буруу ашиглаж хэрэглэвэл галыг улам дэлгэрүүлж унтраахад хүндрэлтэй.

А ангиллын гал унтраагуур нь мод, цаас, хуванцар, В ангиллын гал унтраагуур нь тос, бензин, керосин, будаг зэрэг шингэн галд, С ангиллын гал унтраагуур цахилгаан тоног төхөөрөмж дээр ашигладаг байна.

А ангиллын гал гэдэг нь цаас, мод, хуванцраас бүрдэх гал бөгөөд энэ нь гал унтраагуураар унтраахад хамгийн түгээмэл бөгөөд энгийн галын нэг юм. А ангиллын галыг хянах хамгийн түгээмэл арга бол шатаж буй хатуу түлшийг усаар шүрших замаар дулааныг арилгах явдал юм .

В ангиллын олон галыг (нүүрс устөрөгч, газрын тос болон түүнтэй адилтгах түлш) усаар удирдах боломжгүй байдаг учир нь бензин, тос зэрэг уснаас бага нягтралтай түлш нь усан дээр хөвж, улмаар гал дээр түлшээ шатааж байдаг тул хөөс, нунтаг эсвэл нүүрстөрөгчийн давхар ислийн гал унтраагуураар унтраана.

С ангиллын галыг хуурай нунтаг эсвэл нүүрстөрөгчийн давхар исэл, хуурай химийн ABC гал унтраагуураар хүчилтөрөгчийг зайлуулах замаар үр дүнтэй хянах боломжтой. Цахилгааныг салгасны дараа үр дүн нь А эсвэл В ангиллын гал бөгөөд хөөс эсвэл хуурай химийн нунтаг ашиглан галыг цаашид хянах боломжтой.

D ангиллын галд кали, уран, натри, лити, кальци, плутони зэрэг шатамхай металлууд орно. D ангиллын галыг унтраах хамгийн сайн арга бол хуурай нунтаг гал унтраагуур ашиглах явдал юм. Нунтаг гал унтраагуурыг ашигласнаар галаас үүсэх дулааныг шингээхийн зэрэгцээ галыг унтраадаг.

К ангиллын галд ус хэрэглэж болохгүй, учир нь энэ нь материалыг тарааж, галыг хурдан өсгөхөд хүргэдэг. Энэ тохиолдолд ашиглах хамгийн зөв гал унтраагч бол нойтон химийн гал унтраагуур юм.

Галыг ямар материал шатаж байгаагаас хамаарч Монгол Улсад 6 хэсэгт ангилж байна. Галын ангилал гэдэг нь тэдгээрийг төрөл бүрийн хүч хэрэгсэл унтраах арга, үйлдэл, мөн чанарыг ялган тодруулах үндэс мөн[74].

Гал унтраах арга зүйн үүднээс галын ангилал гэдэг нь харьцангуй ойлголт бөгөөд гагцхүү гал унтраах арга, үйлдлийн байдлыг судлах, шинжилгээ хийх ажлыг хөнгөвчлөх зорилготой билээ.

[74] О.Үржин. П.Цэдэв. С.Баатарсүрэн нарын Аюулгүй амьдрах арга ухааны үндэс-lll. УБ.. 2014. 37 дахь тал

Галын төрлүүдийг A, B, C, D, E, F үсгээр тэмдэглэн ангилж өгдөг.

а. Хатуу бодис материалын гал /A/
б. Хялбар авалцан шатах, шатамхай шингэний гал /B/
в. Шатамхай хийн гал /C/
г. Металлын гал /D/
д. Цахилгаан хүчдэл бүхий гал /E/
е. Байгалийн гаралтай гал /F/[75].

**Төрийн хяналт дахь цахим системийн хэрэглээ, туршлага:**

Цахим мэдээллийн системийн тухай ойлголт: Цахим мэдээллийн систем гэдэг нь мэдээллийг боловсруулж хөгжүүлдэг компьютер болон хүмүүсийн оролцоооос бүрдсэн систем юм. Энэ нэр томьёог заримдаа компьютерийн систем, компьютержсон мэдээллийн санг ажиллуулдаг программ хангамж гэх хязгаарлагдмал хоёрхон зүйл дээр ашигладаг. Мэдээллийн систем гэдэг ухагдахууныг ихэвчлэн эрдэм шинжилгээний судалгаанд ашигладаг ба мэдээллийг цуглуулах, бий болгох, түгээх, ашиглах гэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын харилцаа холбоо, хүмүүс, техник хангамж, программ хангамж бүхий цогц систем гэж ойлгож болно.

Тухайн хяналтын цахим систем нь байгууллагын чанартай, үр ашигтай хяналт шалгалт явуулах, шалгалтын үйл ажиллагааг стандартчилах, ил тод хэрэгжүүлэх, эрсдэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлж байна.

Хяналт шалгалтын үндсэн зорилтыг биелүүлэхэд цахим систем нь онцгой ач холбогдолтой бөгөөд системийг ашигласны үр дүнд эрсдэл ихтэй объектод төвлөрсөн хяналт шалгалтын төлөвлөлт хийх замаар аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

**Гал түймрийн улсын хяналтын өнөөгийн байдлын шинжилгээ**

Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуульд зааснаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч байна гэж заасан байна.

Зураг 3. Нийслэлийн Онцгой байдлын газрын хяналтын бүтэц




Энэ хяналтын хэлтэс нь хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дүн бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байх бөгөөд Барилгын зураг төслийн хяналтын

[75] С.Баттөмөр. Б.Энхтүвшин. Л.Булганхангай нарын Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага. УБ., 2021. 18 дахь тал

тасагтай байна. Энэ тасагт барилгын техникийн гүйцэтгэлийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, барилгын техникийн гүйцэтгэлийн хяналт хариуцсан мэргэжилтэн, барилгын стандарт норм, нормативын хяналт хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, байцаагчийг томилж, чөлөөлөх эрхтэй байна.

Нийслэл хот болон дүүргүүдийн гал түймэртэй тэмцэх хэлтсүүдийн судалгаанаас үзэхэд 15 байцаагч ажиллаж байна. Нийслэл Улаанбаатар хотын захирагч нь Нийслэлийн Онцгой байдлын газрын даргатай байгуулсан гэрээнээс үзэхэд сард 1 байцаагч 60-70 объект шалгах үүрэгтэй байна. Нийслэлийн Онцгой байдлын газар нь аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн галын аюулгүй байдлыг шалгаж, зөрчил илрүүлж арилгах үүргийг хүлээж, жилдээ 70 сая төгрөгийн торгууль төлбөрийг Нийслэл хотын санд төвлөрүүлэх үүргийг хүлээдэг байна.

Чингэлтэй дүүргийн гал түймрийн улсын хяналтын 2019, 2020, 2021 оны харьцуулсан судалгааг дараах байдлаар үзүүлэв (Хүснэгт 1.).,

Хүснэгт 1. Чингэлтэй дүүргийн гал түймоийн улсын хяналтын судалгаа

| Он | Шалгасан объектийн тоо | Илрүүлсэн зөрчлийн тоо | Арилгуулсан зөрчлийн тоо | Заавал биелүүлэх албан шаардлага | Мэдэгдэл | Танилцуулга | Ажиллагаа зогсоох тогтоол | Дүгнэлт | Торгуулийн тоо | Торгууль ноогдуулсан мөнгөн дүн төгрөгөөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2019 он | 1044 | 6224 | 5040 | 237 | 614 | 10 | 14 | 14 | 51 | 25.300.000 |
| 2020 он | 898 | 3431 | 3261 | 363 | 493 | 17 | 4 | 20 | 20 | 14.400.000 |
| 2021 он | 1013 | 2898 | 2756 | 269 | 449 | 14 | 2 | 19 | 18 | 14.800.000 |
| Нийт дүн | 2955 | 12553 | 11057 | 869 | 1556 | 41 | 20 | 53 | 89 | 54.500.000 |

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн “Заавал биелүүлэх албан шаардлага”, “Мэдэгдэл”, “Акт”, “Дүгнэлт”, Тамшиг, аюулт үзэгдэл, осол гарсан тухай акт”, “Зөрчлийн тэмдэглэл”, “Ажиллагаа зогсоох тогтоол”, Тал түймэр гарсан тухай акт”, “Баталгааны тэмдгийн бүртгэл”, “Танилцуулга” зэрэг 10 баримт бичгийг үйлдэж байна.

Гал түймрийн Улсын хяналтын хэрэгжүүлэхэд хамгийн бэрхшээлтэй нь гал түймэр гарч болох зөрчлийг илрүүлэх, улмаар гал түймэрт гарах шалтгааныг тодорхойлж, түүнийг цаг алдалгүй засч арилгуулах асуудал юм. Энэ бол галын техникийн шалгалтын гол зорилго, цаашилбал гал түймрийн хяналтын байцаагчийн үндсэн үүрэг юм.

Чингэлтэй дүүргийн гал түймрийн улсын хяналтын үйл ажиллагаанд SWOT шинжилгээний аргыг хэрэглэн шинжилж дараах хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт 2. SWOT шинжилгээ

| **Strength – давуу тал** | **Weakness – сул тал** |
|---|---|
| **Гал түймрийн улсын хяналтын үйл ажиллагааг явуулах эрх зүйн орчин бүрдсэн.<br>Бусад дүүргүүдтэй харьцуулахад нутаг дэвсгэрийн хэмжээ бага.<br>Хяналт шалгалтад хамрагдах барилга байгууламжийн тоо бага.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт Тэсрэх, дэлбэрэх бодис шатамхай материал ихтэй томоохон объект харьцангуй багатай.** | **Нэг байцаагчид ноогдох байгууллагын тоо их;<br>Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох автомашин байхгүй.<br>Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжид заасан хоорондын хугацаа бага.<br>Гал түймрийн улсын хяналтын байцаагч болон үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн хоорондын үйл ажиллагааг холбосон цахим систем дутмаг.** |

| **Opportunity – боломж** | **Threat – аюул, занал (эрсдэл)** |
|---|---|
| **Гал түймрийн улсын хяналтыг хийж** | **Хуулийн этгээд болох ААНБ-д гал түймрийн** |

| | |
|---|---|
| нийслэлийн төрийн санд оруулж буй мөнгө нь байцаагчийн орон тоог нэмэгдүүлэхэд нөлөөтэй байгаа. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, үйлдвэр үйлчилгээний батламжийг авахад бүрдүүлэх материалын жагсаалтад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт зайлшгүй шаардлагатай байдаг үүнтэй холбоотойгоор иргэд ажлын байрны байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг авч хэвшсэн цаашлаад хяналт шалгалтын хүрээнд галын аюулгүй байдал хангагддаг. | улсын хяналтын үйл ажиллагааг тогтмол тавьж чадахгүй байх. Нийслэл хотод 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 70 гаруй чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулахад тусгай зөвшөөрөл, дүгнэлт шаардлагагүй гэсэн мэдээлэл олон нийтийн сүлжээгээр цацагдсанаар иргэн, хуулийн этгээд өөрийн барилга байгууламжид ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт авах нь эрс багассан. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, хяналтын дүрэм, журам, стандарт, нормын тухай ойлголт, мэдлэг муутай. |

*2.2.* Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад цахим системийг ашиглах боломж

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар Талын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ыг баталсан.

Энэхүү журмаар аж, ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийн дагуу гал түймрийн улсын улсын хяналтын /ахлах/ байцаагчийн шалгалтын дүнг үндэслэн Галын аюулгүй байдлын дүгнэлтийг гал түймрийн онц аюултай барилга байгууламжид 1 жилийн хугацаатай, гал түймрийн аюултай нэгдүгээр зэргийн барилга байгууламжид 2 жилийн хугацаатай, гал түймрийн 2, 3 дугаар зэрэглэлийн барилга байгууламжид 3 жилийн хугацаатай гаргахаар тусгасан байна. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад аж, ахуйн нэгж, байгууллага нь хүсэлт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, барилга байгууламжийг ашиглалтад оруулсан тухай Улсын комиссын дүгнэлт, иргэн нь хүсэлт, иргэний үнэмлэхний хуулбар, түрээсийн барилга байгууламж бол гэрээ зэргийг тухайн нутаг дэвсгэрийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлж ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг үндэслэн Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажлын 10 хүртэлх хоногт хяналт шалгалтыг зохион байгуулж, дүгнэлт олгох боломжтой эсэхийг шийдвэрлэнэ гэж журамд засан байдаг.

**Зураг 6. E-Mongolia.mn" цахим системийн галын дүгнэлт авах булан**




**Дүгнэлт**

Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх арга зүйн үндсийг судлахдаа гал түймрийн хяналт гэж юу болох тухай юуны өмнө авч үзэх нь зүйтэй юм.

Гал түймрийн хяналт гэдэг нь онолын хувьд гал түймрийг үүсгэгч гол элементүүд болох дулаан, агаар (хүчилтөрөгч), түлш (шатах материал)-ыг нөхцөлдүүлэхгүй буюу галын гурвалжинг бий болгохгүй байх, үүсвэрлэн гарсан тохиолдолд цаашид хөгжин дэлгэрүүлэхгүй байх тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл шаталтын процесст оролцож буй элемент бүр, мөн химийн урвалыг нөхцөлдүүлэгчийг багасгах, арилгах, хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг гал түймрийн хяналт гэж ойлгоно.

Гал түймрийн улсын хяналт нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гал түймрийн хяналтын хэлтсийн байцаагч нарын гүйцэтгэдэг

төрийн хяналтын үйл ажиллагааны тусгай төрөл юм.

Нийслэл Улаанбаатар хотын дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсүүдэд нийт 15 гал түймрийн улсын хяналтын байцаагч 46153 идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй иргэн хуулийн этгээдийн барилга байгууламжид хяналт шалгалт зохион байгуулж гал түймэр гарах шалтгаан нөхцөлийг тогтоож илэрсэн зөрчлүүдийг арилгуулах, галын аюулгүй байдал зөрчигдсөн өргөдөл, гомдол шийдвэрлэх, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах зэрэг төрийн үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Судалгаанаас үзэхэд Нийслэл хотын хэмжээнд 1 гал түймрийн улсын хяналтын байцаагчид 3076 барилга байгууламж байгаа нь тухайн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн барилга байгууламжид нэг бүрчлэн хүрч ажиллах боломж нөөц, цаг хугацаанаас шалтгаалсан чанар хүртээмж муу байна тиймээс цаашид энэ төрлийн үйл ажиллагааг цахим системд нэвтрүүлж иргэн хуулийн этгээдтэй хамтран ажиллахад төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Цахим системийг нэвтрүүлж сайжруулснаар чанар, үр ашигтай хяналт шалгалт явуулах, шалгалтын үйл ажиллагааг стандартчилах, ил тод хэрэгжүүлэх, эрсдэлийн төлөв байдал, аюулын зэрэгт дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлэх ба хяналт шалгалтын үндсэн зорилтыг биелүүлэхэд онцгой ач холбогдолтой мэдээллийн системийг ашигласны үр дүнд аюул, эрсдэл ихтэй объектод төвлөрсөн хяналт шалгалтын төлөвлөлт хийх замаар аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг үзүүлнэ.

**Санал**

Гал түймрийн улсын хяналтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийснээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ард иргэдзд цахим систем /Аппликейшн/-ны тусламжтайгаар өөрийн эзэмшлийн барилга байгууламжид галын аюулгүй байдлыг хэрхэн хангах хууль, норм стандартын талаар мэдээлэл болон төрөл бүрийн анхан шатны сургалтыг байршуулах.
2. Цахим үйлчилгээний нэгдсэн “E-Mongolia" системээр иргэн, хуулийн этгээд газар нутаг, орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр лавлагаа, тодорхойлолт, дүгнэлт, акт авах, үйлчилгээний хүсэлт гаргах, шийдвэрлэлтийн тухай мэдээллийг хүлээн авах, санал хүсэлт илгээх нөхцөлийг бүрдүүлэх, хэвшүүлэх.
3. Нийслэлийн /erp.ulaanbaatar.mn/ цахим системийн Онлайн бизнес төв цэсээр дамжуулж хүлээн авч байгаа ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хүсэлтийг шийдвэрлэх 5 хоногийн хуулийн хугацаанд өөрчлөлт оруулах.
4. Галын аюулгүй байдлын тухай хуулийн иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэгт ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг сунгах тухай хугацааг тодорхой тусгах цаашлаад зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгааг анхаарах зэрэг болно.

**Эх сурвалжийн жагсаалт**

Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992.
2. Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2015.
3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/154 дүгээр тушаал, Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам.УБ., 2021.

Хоёр. Сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага

4. Т.Лхамжав. Гал унтраах арга зүй. УБ., 1991.
5. О.Үржин. П.Цэдэв. С.Баатарсүрэн нарын Аюулгүй амьдрах арга ухааны үндэс-Ш. УБ„ 2014.
6. С.Баттөмөр. Б.Энхтүвшин. Л.Булганхангай нарын Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага. УБ., 2021.
7. О.Ганхуяг. Гал түймэр унтраах тактикын гарын авлага. УБ., 2018.